



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/115

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалт, Жендэрийн Үндэсний хорооны 2022 оны 2 дугаар хуралдааны тогтоолын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Батлан хамгаалах салбарт жендэрийн талаар авч хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө (2025-2028)”-г хавсралт ёсоор баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Батлан хамгаалах яамны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөл (Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг), Зэвсэгт хүчний Жанжин штаб (хошууч генерал С.Ганбямба), харьяа аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/18 дугаар тушаалаар батлагдсан “Батлан хамгаалах салбарт жендэрийн талаар баримтлах бодлого батлах тухай” болон мөн сайдын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/300 дугаар тушаалаар батлагдсан “Төлөвлөгөө батлах тухай” тушаалуудыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Б.Эрхэмбаяр)-т даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

1325100190

Батлан хамгаалах сайдын 2025 оны
А/115... дугаар сарын 16-ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ ЖЕНДЭРИЙН ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ (2025-2028)

Төлөвлөгөөний зорилго		Жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлалыг батлан хамгаалах салбарын онцлогтой уялдуулан жендэрийн талаарх ойлголт, хандлагыг дээшлүүлэх, манлайллыг бий болгох замаар салбарын бүх түвшинд жендэрийн мэдрэмжтэй орчныг бүрдүүлэхэд оршино.							
Хүрэх үр дүн		1. Цэргийн алба хаагч, ажилтны жендэр, хүний эрхийн талаарх ойлголт, хандлага дээшилнэ.							
		2. Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлт, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй арга зүйг нэвтрүүлэх нөхцөл бүрдэнэ.							
		3. Салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг ашиглах чадавх дээшилнэ.							
		4. Жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс ангид ажлын орчин бүрдэнэ.							
		5. Батлан хамгаалах салбарт ажиллаж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш боломж олгох, эрхийг нь хамгаалах, хариуцлага тооцох механизм бүрдэнэ.							
№	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хөрөнгийн эх үүсвэр, хэмжээ	Суурь түвшин (2024 он)	Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин		Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
					Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин			
1	2	3	4	5	6	7	8	9	10
Зорилт 1. Салбарын удирдлагын манлайллыг бий болгох замаар жендэрийн мэдрэмжтэй арга зүйг нэвтрүүлэх									
1.1	БХЯ-ны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг явуулах	БХЯ-ны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах	Төсөв, санхүү шаардлагагүй	4 удаа ЖСЗ-ийн хурлыг зохион байгуулсан.	Жилд 2-оос доошгүй удаа яамны дэргэдэх ЖСЗ-ийн хурлыг зохион байгуулсан байх	Төлөвлөлтийн хугацаанд нийт 8-аас доошгүй удаа хуралдаж, хуралдааны шийдвэрийг гүйцэтгэсэн байх	2025-2028	БХЯ-ны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөл	-
1.2		БХЯ-ны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх	Төсөв, санхүү шаардлагагүй	БХС-ын 2015 оны А/352 дугаар тушаал	БХС-ын 1 тушаал батлагдсан байна	БХЯ-ны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэгдсэн байна.	2025 оны 2 дугаар улирал	БХЯ-ны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөл	-

1	2	3	4	5	6	7	8	9	10
1.3		БХЯ, ЗХЖШ, харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудын бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах удирдамж аргачлал боловсруулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх	Төсөв, санхүү шаардлагагүй	-	Зөвлөмж, албан даалгавар, чиглэл боловсруулагдсан байх	Жилд нийт 4-өөс доошгүй мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж, удирдамж, албан даалгавар, чиглэл хүргэгдсэн байна	2025-2028	БХЯ-ны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөл	ЗХЖШ харьяа аж ахуй нэгж байгууллага
1.4	Батлан хамгаалах салбарт удирдлагын манлайллыг бий болгох	Байгууллагууд бодлого, боловсруулалт, төлөвлөлт, төсөвлөлтдөө бүлэг бүрийн төлөөллийг оролцуулдаг байх	Төсөв, санхүү шаардлагагүй	-	Хүний нөөцийн бодлого, байгууллагын дотоод дүрэм, журам зэргийг бүх бүлгийн төлөөллийг оролцуулан баталдаг байх	Шийдвэр гаргах түвшинд эмэгтэй хүйсийн оролцоо нэмэгдсэн байна	2025-2028	Бүх байгууллага	-
1.5		Байгууллагын сургалтын зардлын 5%-ийг хүний эрх-жендэрийн чиглэлийн сургалтад зарцуулах	Улсын төсөв	-	Байгууллагын сургалтын зардлын 5%-аас доошгүй хувийг хүний эрх-жендэрийн чиглэлийн сургалтад зарцуулсан байх	Ажилтан, алба хаагчдын хүний эрх-жендэрийн мэдлэг, хандлага дээшилсэн байна.	2025-2028	Бүх байгууллага	-
1.6	Зохистой хөдөлмөр эрхлэлтийг жендэрийн агуулгаар бэхжүүлж, ажил, ар амьдралын тэнцвэрийг дэмжих ажил	Ажил, ар гэрийн тэнцвэрийг хангасан, жендэрийн мэдрэмжтэй хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагууд мөрдөх	Төсөв, санхүү шаардлагагүй	Батлан хамгаалах салбарт жендэрийн мэдрэмжтэй хөдөлмөрийн дотоод журам боловсруулах зөвлөмж боловсруулагдаж бүх	Холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байх	Бүх байгууллага жендэрийн мэдрэмжтэй хөдөлмөрийн дотоод журам мөрдөж хэвшсэн байна	2025-2028	Бүх байгууллага	-

1	2	3	4	5	6	7	8	9	10
	арга хэмжээг зохион байгуулах			байгууллагад хүргэгдсэн.					
1.7		Хүүхэд төрүүлэх, асрах чөлөө авсан ажилтны мэргэжил, мэргэшлийн ур чадварыг өрсөлдөж чадахуйц түвшинд байлгах зорилгоор шаардлагатай тохиолдолд давтан болон мэргэшүүлэх сургалт хамруулах	80 сая	-	Мэргэшүүлэх сургалтад хүүхэд төрүүлэх, хүүхэд асрах чөлөө авсан ажилтнуудын 10% хамрагдсан байх	Хүүхэд төрүүлэх, асрах чөлөө авсан ажилтны мэргэжил, мэргэшлийн ур чадвар өрсөлдөж чадахуйц түвшинд хадгалагдана	2025-2028	Бүх байгууллага	
1.8	Жендэрийн асуудал хариуцсан хүний нөөцийг бэхжүүлэх	Батлан хамгаалах яам, ЗХЖШ-т жендэрийн орон тооны мэргэжилтэн ажиллуулах	Улсын төсөв	БХЯ, ЗХЖШ-т хавсран гүйцэтгэж байна.	Жендэрийн сургалтад хамрагдсан байх	Жендэрийн асуудал хариуцсан ажилтан томилогдсон байна	2027	БХЯ, ЗХЖШ	
1.9		Батлан хамгаалах яам, ЗХЖШ-ын харьяа байгууллагуудад орон тооны бус мэргэжилтэн ажиллуулах	Улсын төсөв	-	Жендэрийн сургалтад хамрагдсан байх	Батлан хамгаалах салбарын бүх байгууллагад жендэрийн орон тооны бус мэргэжилтэн томилогдсон байна	2025-2028	Бүх байгууллага	БХЯ,ЗХЖШ
1.10	Сургалтын модуль хичээлийн хөтөлбөр боловсруулах	ҮБХИС-ийн сонсогч/оюутан, ХЦАХ-дад зориулсан сургалтын модуль хичээлийн хөтөлбөр боловсруулах	2 сая		Жендэр, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх болон бусад жендэртэй холбоотой асуудлыг тусгасан байх	Сургалтын модуль хичээлийн хөтөлбөр 1 боловсруулагдсан байна	2025	БХЯ, ЗХЖШ-аас томилогдсон ажлын хэсэг	Жендэрийн Үндэсний хороо
1.11		Батлан хамгаалах салбарын ажилтан, алба хаагчдад зориулсан сургалтын модуль хичээлийн хөтөлбөр боловсруулах	2 сая		Жендэр, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх болон бусад жендэртэй холбоотой асуудлыг тусгасан байх	Сургалтын модуль хичээлийн хөтөлбөр 1 боловсруулагдсан байна	2025	БХЯ, ЗХЖШ-аас томилогдсон ажлын хэсэг	Жендэрийн Үндэсний хороо

1	2	3	4	5	6	7	8	9	10
1.12		ЭДА-нд үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнд зориулсан сургалтын хичээлийн модуль хөтөлбөр боловсруулах	2 сая	Эмэгтэйчүүд энх тайван ба аюулгүй байдал сургалт зохион байгуулагдсан	Жендэр, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх болон ЭДА-нд үүрэг гүйцэтгэх үед тулгарч болох жендэртэй холбоотой асуудлыг тусгасан байх	Сургалтын модуль хичээлийн хөтөлбөр 1 боловсруулагдсан байна	2025	БХЯ, ЗХЖШ-аас томилогдсон ажлын хэсэг	Жендэрийн Үндэсний хороо
Зорилт 2. Жендэрийн мэдрэмжтэй салбар, орчныг бүрдүүлэх									
2.1	Ажил, ар гэрийн тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, ажилтан, алба хаагчдын хүүхдүүдэд эх оронч үзэл төлөвшүүлэх хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх	Салбарын нийт ажилтан, алба хаагчдын хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг батлан хамгаалах салбарын байгууллага бүр тухайн оны 10 дугаар сарын 01-ны байдлаар гаргах	Төсөв, санхүү шаардлагагүй	-	Судалгаанд тавигдах шаардлагыг хангасан байх	Хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх нөхцөлийг тодорхойлоход ашиглагдсан байна.	2025-2028	Бүх байгууллага	-
2.2		Хүүхдийн судалгаанд үндэслэн хүүхдэд ээлтэй төсөл, ажил, арга хэмжээ зохион байгуулах	Улсын төсөв болон бусад эх үүсвэр	-	Хүүхдэд ээлтэй орчин нөхцөл бүрдэнэ	Жилд 2-оос доошгүй удаа зөвлөгөө өгөх болон нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна.	2025-2028	Бүх байгууллага	Эцэг, эхийн зөвлөл (Эмэгтэйчүү-дийн зөвлөл)
2.3		Зэвсэгт хүчний анги, байгууллагад хүүхэд саатуулах булан, өрөөг тохижуулсан байх	32 сая	Хүүхэд саатуулах өрөө-4	Хүүхдэд эх оронч үзэл төлөвшүүлэх агуулгыг багтаасан байх	Жилд 2-оос доошгүй байгууллагад дэмжлэг үзүүлэх	2025-2028	БХЯ, ЗХЖШ	Бүх байгууллага
2.4		Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний гэр бүлийн гишүүн, тэдний үр хүүхдүүдийг спорт хороонд хичээллэж буй спортын 18 төрлийн секц, дугуйлан, БТЧТ-өөр үйлчлүүлэх	Улсын төсөв болон бусад эх үүсвэр	-	Аюулгүй ажиллагаа, хөдөлмөр, аюулгүй байдлыг хангасан байх	Жилд 400-аас доошгүй хүүхэд спорт хороонд хичээллэсэн байх	2025-2028	Алдар спорт хороо	-

1	2	3	4	5	6	7	8	9	10
2.5		Хүүхэд асрах чөлөөтэй байгаа эмэгтэйчүүдийг мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх боломжоор хангах, цолны болон төрийн, салбарын шагналаар шагнах нөхцөлийг бүрдүүлэх	Төсөв, санхүү шаардлагагүй	-	Тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдах	20-оос доошгүй хүүхэд асрах чөлөөтэй эмэгтэй хамрагдсан байх	2025-2028	Бүх байгууллага	-
2.6	Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй эхнэр (нөхөр), байнгын асаргаатай хүүхэд, өндөр настай эцэг, эхээ асардаг, бага орлоготой, өрх толгойлсон цэргийн алба хаагч, ажилтны талаар	Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй эхнэр (нөхөр), байнгын асаргаатай хүүхэд, өндөр настай эцэг, эхээ асардаг, бага орлоготой, өрх толгойлсон цэргийн алба хаагч, ажилтны талаар дэлгэрэнгүй судалгаа гаргаж, мэдээллийн сан үүсгэн баяжуулах	Төсөв, санхүү шаардлагагүй	-	Статистик судалгаанд тавигдах шаардлагыг хангасан байх	Дэлгэрэнгүй судалгаа гаргаж, мэдээллийн сан үүсгэж, баяжуулсан байна.	2025-2028	Бүх байгууллага	-
2.7	дэлгэрэнгүй судалгаа гаргаж, тэдний амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Судалгаанд тулгуурлан жендэрийн мэдрэмжтэй төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	40 сая	-	Судалгаанд тулгуурласан байх	Жилд жендэрийн мэдрэмжтэй үйл ажиллагаа 10-аас доошгүй зохион байгуулагдсан байх	2025-2028	Бүх байгууллага	-
2.8	Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетийг Цэргийн төв	Цэргийн төв эмнэлгийн Андрологийн кабинетын үйл ажиллагааг жигдрүүлэх, спермограммын шинжилгээг	Улсын төсөв болон гадаадын зээл, тусламж	Андрологийн кабинетын үйл ажиллагаа эхэлсэн	Эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадвар дээшилсэн, тоног төхөөрөмж, хэрэгсэл сайжирсан байх	Нийт үйлчилгээ үзүүлсэн хүний тоо жилд 100-аас доошгүй байх	2025-2028	ЦТЭ	БХЯ

1	2	3	4	5	6	7	8	9	10
	эмнэлэгт жигдрүүлэх, оношилгоо, эмчилгээний шинэ техник, технологийг нэвтрүүлэх	нэвтрүүлж, оношилгоо сайжруулах							
2.9		Эмч, мэргэжилтнийг сургалтад хамруулах	Улсын төсөв болон гадаадын зээл, тусламж		Эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадвар дээшилсэн байх	Жилд 1-ээс доошгүй сургалтад хамруулах	2025-2028	ЦТЭ	БХЯ
2.10		Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаар мэдээлэл сурталчилгааны материал боловсруулж, зохион байгуулах	Улсын төсөв болон гадаадын зээл, тусламж	-	Салбар, улсын хэмжээнд түгээсэн байх	Жилд 1 удаа мэдээлэл, сурталчилгаа явуулсан байх	2025-2028	ЦТЭ	ТЗУГ
2.11	"Цэргийн алба хаагчийн гэр бүлийн гишүүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх" журмыг хэрэгжүүлж, ЦТЭ-ийн хүүхдийн тасаг, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний кабинетын үйл ажиллагааг явуулах	ЦТЭ-ийн хүүхдийн тасаг, эмэгтэйчүүдийн эмчийн хүний нөөц, тусламж, үйлчилгээний кабинетын үйл ажиллагааг сайжруулах	Улсын төсөв болон гадаадын зээл, тусламж	ЦТЭ-ийн хүүхдийн тасаг, эмэгтэйчүүдийн кабинет	Хууль тогтоомжийн төсөл, Засгийн газрын шийдвэр, Батлан хамгаалахын сайдын тушаал	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна.	2025-2028	БХЯ ЦТЭ	-
2.12		Эмч, мэргэжилтнийг сургалтад хамруулах	Улсын төсөв болон гадаадын зээл, тусламж	-	Эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадвар дээшилсэн байх	Жилд 1-ээс доошгүй сургалтад хамруулах	2025-2028	ЦТЭ	БХЯ
2.13		Мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулах	Улсын төсөв болон гадаадын зээл, тусламж	-	Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо, зохион байгуулсан мэдээлэл, сурталчилгааны тоо	Жил бүр мэдээлэл сурталчилгааны ажил 2-оос доошгүй зохион байгуулсан байна.	2025-2028	ЦТЭ	-

1	2	3	4	5	6	7	8	9	10
2.14		Хүүхэд, эмэгтэйчүүдийн эмчийн хүний нөөцийг нэмэгдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, табель хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх	Улсын төсөв болон гадаадын зээл, тусламж	-	Эмч, эмнэлгийн техник, тоног төхөөрөмжид тавигдах шаардлагыг хангасан байх	Хүүхэд, эмэгтэйчүүдийн эмчийн хүний нөөц нэмэгдэж, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, табель хэрэгслээр хангагдсан байна.	2025-2028	БХЯ, ЗХЖШ, ЦТЭ	-
2.15	ЦТЭ болон хугацаат цэргийн алба хаагчтай анги, байгууллагын эмнэлгийн нэгжид нийгмийн эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийг	ЦТЭ болон хугацаат цэргийн алба хаагчтай анги, байгууллагын эмнэлгийн нэгжид нийгмийн эрүүл мэндийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх	Улсын төсөв		Ажилчин албан хаагчдын нийгмийн эрүүл мэнд дээшилсэн байна	ЦТЭ болон Зэвсэгт хүчний 10-аас доошгүй нэгтгэл, ангийн нийгмийн эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийг нэмэгдүүлсэн байна.	2025-2028	СБТГ, ТЗУГ, ЗХЖШ, ЦТЭ	
2.16	нэмэгдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, табель хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх	Шаардлагатай техник, тоног төхөөрөмж, табель хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх	Улсын төсөв	-	Нийгмийн эрүүл мэндийн ажилтны ажиглах нөхцөл бүрдсэн байх	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна.	2025-2028	СБТГ, ЗХЖШ, ЦТЭ,	
2.17	Алслагдсан нутагт ажиллаж буй цэргийн алба хаагчийн эхнэр (нөхөр)-ийн нийгмийн	Алслагдсан нутагт ажиллаж буй цэргийн алба хаагчийн дэлгэрэнгүй судалгааг гаргасан байх	Төсөв, санхүү шаардлагагүй		Үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болох мэдээллийн сан бүрдэнэ.	Судалгааг жил бүр 2-оос доошгүй удаа гаргасан байх	2025-2028	ЗХЖШ	ТХК, удирдах газар
2.18	идэвхтэй оролцоог хангасан үйл ажиллагааг зохион байгуулах	Цэргийн алба хаагчийн эхнэр(нөхөр)-ийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх	Улсын төсөв		Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт хангагдана	Жил бүрийн 11 дүгээр сард тайланг нэгтгэсэн байна.	2025-2028	ЗХЖШ	ТХК, удирдах газар

1	2	3	4	5	6	7	8	9	10
Зорилт 3. Салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх, ашиглах чадавхыг дээшлүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс ангид ажлын орчныг бий болгох									
3.1	Салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх, холбогдох задаргаагаар өргөжүүлж, дүн шинжилгээ хийх, ашиглах	Салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээлэл бүрдүүлэх	Төсөв санхүү шаардлагагүй	-	Статистик мэдээлэл бүрдүүлэхэд тавигдах шаардлагыг хангасан байна.	Статистик мэдээ, судалгааг жил бүр 2-оос доошгүй удаа гаргасан байна.	Жил бүрийн VI, XII сард	ЗХЖШ, яамны харьяа аж ахуй нэгж байгууллагууд	Жендэрийн салбар зөвлөл
3.2		Бүх төрлийн үйл ажиллагааны оролцогч, үр шим хүртэгчийг хүйсээр ангилж бүх төрлийн тайланд тусгаж хэвших	Төсөв санхүү шаардлагагүй	-	Статистик мэдээлэл бүрдүүлэхэд тавигдах шаардлагыг хангасан байна.	Бүх төрлийн үйл ажиллагааны оролцогч, үр шим хүртэгчийн мэдээлэл хүйсээр ангилагдсан байна.	2025-2028	Бүх байгууллага	
3.3	Салбарт ажиллаж буй нийт бие бүрэлдэхүүний тулгамдаж буй асуудалд судалгаа явуулах, зөвлөмж боловсруулж, хэрэгжүүлэх	Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчдын гэр бүлд тулгамдаж байгаа асуудал сэдвээр судалгаа явуулах	5 сая	ШУТЗ. "Батлан хамгаалах салбарын жендэрийн нөхцөл байдлын судалгаа"-ны тайлан. 2018 он.	Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоол. "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"-д нийцсэн байх	Судалгааны тайлан хийгдсэн байна.	2026	БХЭШХ, ЗХЖШ	ТХК, удирдах газар, нэгтгэл ангиуд
3.4		Салбарт ажиллаж буй нийт бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн байдал сэдвээр судалгаа явуулах	5 сая	ШУТЗ. "Батлан хамгаалах салбарын жендэрийн нөхцөл байдлын судалгаа"-ны тайлан. 2018 он.	Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоол. "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"-д нийцсэн байх	Судалгааны тайлан хийгдсэн байх	2027	БХЭШХ	ЦТЭ

1	2	3	4	5	6	7	8	9	10
3.5		Судалгааны тайлан үндэслэн зөвлөмж боловсруулах, холбогдох удирдлагад танилцуулах	Төсөв санхүү шаардлагагүй	-	Судалгааны тайланд үндэслэсэн байна.	2 илтгэх хуудас удирдлагад танилцуулагдаж, 2 зөвлөмж боловсруулж, яамны харьяа байгууллагуудад хүргэгдсэн байна.	2026-2027	ЖСЗ	ЗХЖШ
3.6	Жендэрт суурилсан аливаа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүнээс ангид байх орчныг бүрдүүлэх	БХЯ-ны Жендэрийн салбар зөвлөл, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах	20 сая	-	Үр дүнд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Жилд 1-ээс доошгүй төрийн бус байгууллагатай хамтран ажилласан байна.	2025-2028	БХЯ-ны Жендэрийн салбар зөвлөл, "Гэмт хэрэг, сахилга, дэг журмаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөл	Төрийн бус байгууллага
3.7		Жендэрт суурилсан аливаа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүнээс ангид байх орчныг бүрдүүлэх	20 сая	-	Сахилга, дэг журам сайжирсан байх	Жендэрт суурилсан аливаа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх 10-аас доошгүй ажил, арга хэмжээ зохион байгуулсан байна	2025-2028	БХЯ, ЗХЖШ	Бүх байгууллага
3.8		Гомдол саналыг шийдвэрлэх	Төсөв, хөрөнгө шаардахгүй	-	Жендэрт суурилсан аливаа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтай холбоотой санал, гомдлыг нууцлалыг хангасан байх	Жендэрт суурилсан аливаа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтай холбоотой санал, гомдлыг 100% шийдвэрлэсэн байна.	2025-2028	Бүх байгууллага	-

1	2	3	4	5	6	7	8	9	10
3.9	Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх "Цагаан туузтаны 16 хоногийн аян"-д нэгдэх, зохион байгуулах	8 сая	Салбарын хэмжээнд жилд 10-аас доошгүй байгууллага нэгдэж хэвшсэн.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийн шаардлагыг хангах	Аянд нэгдсэн байгууллагын тоо жилд 10-аас доошгүй байна.	Жил бүрийн XI-XII сард	Бүх байгууллага	-
3.10	Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах	"Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр", "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан өрнүүлдэг "Харилцан хүндэтгэе" аянд нэгдэх, зохион байгуулах	8 сая	Салбарын хэмжээнд жилд 10-аас доошгүй байгууллага нэгдэж хэвшсэн.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийн шаардлагыг хангах	Аянд нэгдсэн байгууллагын тоо жилд 10-аас доошгүй байна.	Жил бүрийн XI-XII сард	Бүх байгууллага	-
Зорилт 4. Жендэрийн хэвшмэл ойлголт, тэгш байдлыг хангах талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлж, хүний нөөцийг сургаж бэлтгэх									
4.1	Жендэрийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, оролцох	Жендерийн цахим сургалтад удирдах болон захиргааны ажилтнуудыг хамруулах	Төсөв санхүү шаардлагагүй	-	Шинээр томилогдсон албаны даргаас дээш албан тушаалтын зэрэглэлтэй удирдах бүрэлдэхүүн хамрагдсан байх	Удирдах болон захиргааны ажилтнууд хамрагдсан байх	2025-2028	Бүх байгууллага	-
4.2	Жендэрийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, оролцох	Жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх чадавхыг эзэмшүүлэх мэргэжил, арга зүйн сургалтад жендэр, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнийг хамруулах	10 сая	Зохион байгуулсан сургалт-2, жендэрийн сургагч багш-2	Сургалт зохион байгуулахад тавигдах нийтлэг шаардлагыг хангасан байх	Сургагч багш бэлтгэх сургалт 1-ийг зохион байгуулсан байх	2025-2028	БХЯ, ЗХЖШ ЖҮХ-той хамтран зохион байгуулах	-

1	2	3	4	5	6	7	8	9	10
4.3		Батлагдсан модуль сургалтын хөтөлбөрийн дагуу ҮБХИС-ийн сонсогч, оюутан, ХЦАХ нарт жендэрийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх сургалт явуулах	16 сая	-	Модуль сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан байх	Жилд 2000-аас доошгүй хүн хамрагдсан байна	2025-2028	ҮБХИС, ЗХЖШ	ХЦАХ-тай анги, нэгтгэл
4.4		Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчдыг жендэрийн хэвшмэл ойлголт, ажлын байран дахь бэлгийн дарамт, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс ангид орчныг бүрдүүлэх асуудлыг тусгасан сургалтыг зохион байгуулах	Төсөв санхүү шаардлагагүй	Зохион байгуулсан сургалт 2	Сургалтын хөтөлбөрт тусгасан байдал, түүнд хамрагдсан хүний тоо, эзлэх хувь	Сургалтын хөтөлбөрт тусгасан байна.	2025-2028	ЗХЖШ	-
4.5	Бие бүрэлдэхүүний дунд бусдыг хүндлэх,	Сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	20 сая	-	1000 доошгүй хүн сургалтад хамрагдсан байх	Байгууллага бүр 1 үйл ажиллагаа зохион байгуулсан байх	2025-2028	Бүх байгууллага	Төрийн болон төрийн бус байгууллага
4.6	хүчирхийлэгч бус байх, гэр бүлийн болон ойр дотно хүнээ хайрлан хүндэтгэх, хүнлэг чанарыг эрхэмлэх, өрх гэрийн үүрэг, хариуцлага, гэр бүлийн харилцаан дахь эмэгтэй, эрэгтэй	Салбарын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүчирхийлэгч бус байх, гэр бүлийн болон ойр дотно хүнээ хайрлан хүндэтгэх, хүнлэг чанарыг эрхэмлэх, өрх гэрийн үүрэг, хариуцлага, гэр бүлийн харилцаан дахь эмэгтэй, эрэгтэй	Төсөв санхүү шаардлагагүй	-	Улиралд 1-ээс доошгүй нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж хүргэсэн байх		2025-2028	Соёмбо редакц	-

1	2	3	4	5	6	7	8	9	10
	хүмүүсийн тэгш оролцоог дэмжих, эрүүл амьдралын зан үйлд суралцаж, хорт буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах	хүмүүсийн тэгш оролцоог дэмжих, эрүүл амьдралын зан үйлд суралцаж, хорт буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр жендэрийн холбогдолтой нийтлэл, мэдээ, нэвтрүүлэг бэлтгэж түгээх							
4.7		Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах	Төсөв санхүү шаардлагагүй	-	100 доошгүй хүн зөвлөгөө авсан байх	Сэтгэл зүйн зөвлөгөө-2	2025-2028	Бүх байгууллага	ЦТЭ болон бусад ажилтан байгууллагуудтай
4.8	Дунд хугацааны төлөвлөгөө 2025-2028-нд явцын үнэлгээ хийх	"Батлан хамгаалах салбарт жендэрийн талаар авч хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө (2025-2028 он)"-д явцын үнэлгээ хийх	Төсөв, хөрөнгө шаардахгүй	-	Жилд 2-оос доошгүй удаа үнэлгээ хийгдэж, ЖҮХ-ны хороонд хүргүүлсэн байх	Төлөвлөгөөний хэрэгжилт сайжирна.	2025-2028	Жендэрийн салбар зөвлөл	БХЯ-ХШҮДАГ
4.9		Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан байгууллага, ажилтан, алба хаагчийг урамшуулах	3.2 сая	-	Үр дүнд суурилсан байна	Жилд 1 байгууллага, 3 албан хаагчийг урамшуулсан байна.	2025-2028	Жендэрийн салбар зөвлөл	ЗХЖШ
4.10		Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуй, нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлагыг түгээх	Төсөв, санхүү шаардлагагүй	-	Соёмбо сонин, дуулга студиэр дамжуулан ажилтан, алба хаагчдад сурталчилсан байх	Жилд 4 сайн туршлагыг салбарын хэмжээнд сурталчилж, түгээсэн байна	Улирал тутам	Соёмбо редакц	Жендэрийн салбар зөвлөл

1	2	3	4	5	6	7	8	9	10
Зорилт 5. Батлан хамгаалах салбарт "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2024-2027"-г хэрэгжүүлэх									
5.1	"Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2024-2027"-г хэрэгжүүлэх	"Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2024-2027"-г таниулах ажлыг зохион байгуулах	Төсөв, санхүү шаардлагагүй	БХЯ, ЗХЖШ-ын бие бүрэлдэхүүнд танилцуулсан	ЖҮХ-оос гаргасан танилцуулгын хүрээнд явуулсан байх	Салбарын хэмжээнд төлөвлөгөөг танилцуулсан байна.	2025	Бүх байгууллага	-
5.2	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг жил бүр зохион байгуулахаар тусгаж, эрэгтэй албан хаагчдын хамрагдалт, оролцсон байдалд тусгайлан анхаарах	Төсөв, санхүү шаардлагагүй	50%	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт сайжирсан байх	Бүх байгууллага жендэрийн мэдрэмжтэй хөдөлмөрийн дотоод журам эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хамруулах заалтыг тусгасан байна.	2025-2028	Бүх байгууллага	-
5.3		Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах	Эрүүл мэндийн даатгалаар		Ажилтан, алба хаагчид 100% хамрагдсан байх		2025-2028	Бүх байгууллага	ЦТЭ, орон нутаг дах эрүүл мэндийн байгууллага
5.4	Эрүүл амьдралын хэв маягийг сурталчилсан уриалга, арга хэмжээнд идэвхтэй оролцох	Эрэгтэйчүүдийн сонирхлоор нэгдсэн клуб, спортын төрлөөр дамжуулан эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлах, зөв үлгэр дуурайлал үзүүлж буй бүлэг, клубийг дэмжих, сурталчлах	10 сая	-	Олон нийтийн хэрэгслээр түгээн дэлгэрүүлсэн байх	Жилд 2-оос доошгүй эрэгтэйчүүдийн сонирхлоор нэгдсэн клуб, спортын төрлөөр дамжуулан эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлах	2025-2028	БХЯ, ЗХЖШ	Соёмбо редакц

1	2	3	4	5	6	7	8	9	10
5.5		Зүрх судас, артерийн даралт ихсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор артерийн даралтаа хэмжих, хянахад хэвшүүлэх, "80/120" богино хугацааны нөлөөллийн аяныг жил бүрийн 3 дугаар сард зохион байгуулах	Төсөв, санхүү шаардлагагүй	-	20-оос дээш насны эрэгтэй алба хаагчдыг 100 хувь хамруулсан байх	Ажилтан, алба хаагчид артерийн даралтаа хэмжих, хянахад хэвшсэн байна.	Жил бүрийн 3 дугаар сард	Бүх байгууллага	-
5.6	Хугацаат цэргийн албанд татагдаж буй эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэлд тулгуурлан цэргийн насны залуучуудын эрүүл мэндэд тулгамдаж байгаа асуудлаар судалгаа явуулах	ХЦА-д татагдаж буй эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэлд тулгуурлан цэргийн насны залуучуудын эрүүл мэндэд тулгамдаж байгаа асуудлаар судалгаа явуулах	Улсын төлөв болон бусад эх үүсвэр	-	Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоол. "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"-д нийцсэн байх	Судалгааны тайлан хийгдсэн байна.	2025-2028	БХЭШХ, ЦТЭ	БХЯ, Цэргийн штаб
Зорилт 6. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход жендэрийн тэгш оролцоог хангах									
6.1	Батлан хамгаалах салбарын байгууллагуудад ногоон хотхон байгуулах, агро ойжуулалтыг хөгжүүлэх төслийн хүрээнд ногоон ажлын	Зэвсэгт хүчний алба хаагчдыг амьдарч буй орчиндоо мод тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөлд жендэрийн мэдрэмжтэй аргачлал нэвтрүүлэх зөвлөмж хүргүүлэх	Улсын төлөв болон бусад эх үүсвэр	Зэвсэгт хүчний 7 нэгтгэл ангид эко хотхон байгуулсан	Цэргийн анги, байгууллага хотхонд ногоон байгууламж байгуулах арчлах арга зүйн зөвлөмж хүргүүлнэ	Алба хаагчдын эрүүл хүнс үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	2025-2028	ЗХЖШ	ТХК, удирдах газар

1	2	3	4	5	6	7	8	9	10
6.2	байрны шалгуур үзүүлэлтийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулж нэвтрүүлэх	Жендэрийн мэдрэмжтэй жишиг ногоон суурин, хотхоныг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх	Улсын төлөв болон бусад эх үүсвэр	Эко хотхон сурталчлан ажилласан тоо-7	Ногоон байгууламжийн хэрэгжилтийг хангасан	Алба хаагчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлнэ	2025-2028	ЗХЖШ	ТХК, удирдах газар

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ